

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Ухнаа	Дугаар	L093
Оршин суугаа аймаг	Хэнтий	Оршин суугаа сум	Дархан
Төрсөн газар	Дархан сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Ахай бэйсийн хүрээ	Сүм хийдийн дугаар	ХЭДР 024
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сарын 19	Ярилцлага авсан хүн	Ж.Одгарьд



Хэнтий аймгийн Дархан сумын Ахай бэйсийн хүрээ

-Бид сүм хийдийн судалгааны ажлаар явж байна. Танаас танай нутагт байсан хуучны сүм хийдийн тухай асууж сурахаар явж байна.

Би бас хагас хугас мэднэ штээ. Нэг хурал Шавартын адагт байсан гэдэг. Цээлийн эхэнд нэг байсан. Цээлийн эхнийх чинь одоо энд ирээд байгаа юм. Энэ Ганданшадавлин. Энд чинь хамба лам нь байхгүй орлогч нь байсан. Нэг зурхайч байсан. Гурав хоногийн дотор нүүж буу гэсэн. Хошуу отгоороо цуглаад ярилцсан. Тэгээд амжина гэсэн. Гурав хоногийн дотор нүүгээд яг буусан гэдэг. Яг буусны дараа хуучин тэр газарт нь үер буугаад манз цавын хоёр тогоо үлдсэн байсныг манайхны Маналжав гэдэг хүн тэгж ярьж байсан. Урсгаад Тогоотын хонхор гэдэг газраас олдоод тэр газар нь ийм нэртэй болсон. Тэгээд түшлэгтэй сандал хэлбэртэй газар буулгалаа шүү. Ингээд харахад эхийн хэвлий маягтай хүн тасрахгүй байх аа гэсэн хэлсэн гэдэг түүхтэй юм.

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

-Бид Б. Ринчений судалгаан дээр тулгуурлан явж байгаа. Энд Дархан сумд 10-аад сүм хийд тэмдэглэгдсэн байна. Ахай бэйсийн хүрээ, Цамбалхүндэвийн хийд Гурван овоо гэдэг газар байдаг гэж байна.

Гурван овоо гэдэг газар байдаг гэж байхаар Доргонотыг л хэлж байгаа юм болов уу? Батсүхийн зүүнтэй туурь байдаг. Гурван овоот гэдэг чинь тэр.

-Хараатын хийд гэж, Хараа өндөр уул гэдэг газар байдаг гэж байна?

2-р бригадын төв. Бор-Өндөрийн наахна байдаг.

-Хавцалын хийд, Дээд, Доод хурал гэж хоёр байсан юм уу?

Тийм хоёр байсан юм.

-Бүүрийн хурал гэж Рашаантын хурал гэж нэрлэгдэж байсан ч байна?

Бөөрийн рашаан юм байна. Тэнд хурал байсныг мэдэхгүй юм байна.

-Хүйхийн хурал гэж байсан байна?

Хүйх гэж газар бий. Хурал байсныг мэдэхгүй.

-Таван толгойн хурал гэж байсан байна?

Хошууны хурал байх.

-Тоорын хурал Жаргалант гэдэг газар байдаг? Долоодын хурал гэж нэрлэж байгаа.

-Гээзэгийн хурал гэж байсан байна?

Байсан.

-Элэгний хурал гэж байсан байна?

Элгэн энгэр гэж хойно бий л дээ. Тэнд хурал байсан үгүйг мэдэхгүй байна.

-Босгоны хурал гэж дуулсан уу?

Газрыг нь мэднэ. Хурал байсныг нь мэдэхгүй. Зүүн Мандалд нэг хурал байсан. Дэрсэн усны хурал гэж байсан.

Буурийг нь мэдэхээс биш, яг хурлын тухай мэдэхгүй. Халзан Содов, Буриа Шарав гэж жасын нярав байж байгаад тэгсээр тэгсээр байхгүй болсон. Буриа Шаравын үед л устсан.

Хэдэн онд устсан юм бол?

Аа мэдэхгүй.